

## Зориулалт

Цонх болон хаалганы блок суурилуулах, цонхны тавцан, хананы хавтанг бэхлэх, хагарал болон хоосон зайг чигжих, завсарын дулаан болон дуу чимээ тусгаарлах түүнчлэн бусад барилга угсралт, өнгөлгөөний ажилд зориулагдсан. Өндөр чанарын нэг бүрэлдэхүүнт полиуретан угсралтын хөөс нь бетон, тоосго, гипс, мод, хуванцар гэх мэт полиэтилен, полипропилен, фторопластикаас бусад барилгын ихэнх материалд маш сайн наалдаж өгдөг. Нэгэн жигд, тогтвортой гаралтыг хангаж, бэлэн болсон хөөс нь гайхалтай нятралтай бүтцийг бий болгодог.

## Хэрэглэх заавар

- Ажлыг -10°C-аас +35°C хүртэл температурт, агаарын харьцангуй чийгшил 50%-аас доошгүй үед хийхийг зөвлөж байна.
- Хөөсний физик-механикийн үзүүлэлтүүдийн оновчтой байдал болон их хэмжээгээр гаргахын тулд ашиглахын өмнө баллоныг +18 °C-ээс +20 °C-ын хэмд 10 цагаас багагүй хугацаанд байлгах хэрэгтэй.
- Цэвэрхэн ажиллахын тулд зэргэлдээх гадаргууг будагын скочоор хучихыг зөвлөж байна.
- Урьдчилж тоос, шавар, тос, мөс, хяруу зэрэг бохирдлыг цэвэрлэсэн гадаргуу дээр хөөсийг хэрэглэнэ.
- Хөөсийг хэрэглэхээс өмнө орчны температур 0°C-ээс дээш температурт ажиллах гадаргууг чийгшүүлнэ.
- Баллоныг доош харуулсан байдалтай ажиллана.
- Хамгаалалтын тагийг авна.
- Полиэтилен хоолойтой адаптерийг баллоны хавхлага руу шургуулна.
- Баллоныг 30 секундын турш 15-аас доошгүй удаа сайтар сэгсэрнэ.
- Угсралтын хөөсийг доороос дээш чиглэлтэйгээр хагархайн 1/2 хэсгийг дүүргэж түрхэнэ.
- Хөөсний гаралтыг адаптер дээр дарж тохируулж болно.
- Ашиглалтын явцад баллоныг тогтмол сэгсэрнэ.
- Хэрэглэсний дараа хөөсийг орчны 0° C-ээс дээш температурт шүршигчийн түслэмжтэй усаар чийгшүүлнэ.
- Үндсэн боловсруулалтын хугацаа – 1цаг \*\*.
- Бүрэн хатуурсны дараа илүүдэл хөөсийг хутгаар зүсэж авна.
- Хатаагүй хөөсийг «Очистителем монтажной пены» "Угсралтын хөөс цэвэрлэгч" ашиглан арилгана.
- Хатуурсан хөөсөнд «Удалитель застывшей монтажной пены» "Хатсан угсралтын хөөс арилгагч" хэрэглэнэ.
- Бүрэн полимержилтын дараа (24-48 цаг) хатуурсан хөөсийг зүсэж, гипсдэж, будаж болно.
- Хэт ягаан туяа болон хур тунадасын нөлөөллөөс хамгаална.

Өнгө	Цагаан
Хөөсний гаралт	50литр хүртэл
Зүсэлтийн бүтэц	Нэг төрлийн нарийн сүвэрхэг
Арьс үүсэх хугацаа	10минут хүртэл
Үндсэн боловсруулалтын хугацаа	40минут
Бүрэн полимержих хугацаа	24-48цаг
Нятрал	15-30кг/м3
Орчны температур	-10°C...+35°C
Баллоны температур	+15°C...+35°C
Хатуурсан хөөсний дулаан тэсвэрлэх чадвар	-40°C...+90°C
Хадгалах температур	+5°C...+25°C

*\*\*23 °C температурт, агаарын харьцангуй чийгшил 50%*

**Хадгалах хугацаа: Хадгалах горимыг хангасан тохиолдолд 24 сар**

**Хэмжээ: 1000 мл**

**EAN: 4606445025996**  
**ITF: 14606445025993**  
**KUPH10U50+**

